



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2015 оны 11 дүгээр сар

Гадаад худалдааны эргэлт: \$7,737.5 сая

Мөнгөн дүн тайлант хугацааны эцэст 7,737.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 22.8%-иар буюу 2,285.0 сая ам.доллараар буурсан. Үүнд экспорт 947.5 сая ам.доллараар, импорт 1,337.5 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв.

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 62.4% буюу 4,831.9 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 13.0% буюу 1,002.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай тус тус хийсэн байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 21.9%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 32.5%-иар тус тус буурчээ.

Гадаад худалдааны нийт тэнцэл: \$748.2 сая

Мөнгөн дүн 2015 оны эхний 11 сарын байдлаар гадаад худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 390.0 сая ам.доллараар нэмэгдсэнээр 748.2 сая ам.долларын ашигтай гарлаа. Энэ нь экспорт 18.3%-иар буурсан ч импорт түүнээс өндөр дүнгээр буюу 27.7%-иар буурсантай холбоотой байна.

Экспорт, импортын жилийн өсөлтийн зөрүүг 3 сарын гулсах дунджаар (moving average) авч үзвэл сүүлийн жилүүдэд байнгын бууралттай байсан боловч 2014 оны эхнээс экспортын өсөлт нэмэгдэж, импортын өсөлт буурсан тул жилийн өсөлтийн зөрүү нэмэгдсэн. Харин 2015 он гарсаар зэсийн баяжмалын экспортын нөлөө тогтворжиж, барааны эргэлтийн өсөлт буурч байна.

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл: \$1041.2

Валютаар төлбөр тооцоог нь гүйцэтгэсэн худалдааны тэнцэл нь төгрөгийн валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь үзүүлэлт юм. Сүүлийн 2 жилийн хугацаанд тогтмол алдагдалтай байсан валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2014 оны сүүлийн хагасаас эхлэн тогтмол ашигтай гарч байна. 2015 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1,041.2 сая ам.долларын ашигтай буюу өнгөрсөн оны мөн үеэс 390.7 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлттэй байна. Үүнд валютын төлбөртэй импорт 30.6%-иар буурсан нь нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөл: 1.254 (Туршилт тооцоо)


2015 оны 11 дүгээр сарын байдлаар гадаад худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс 21.3%-иар, өмнөх сараас 10.9%-иар буурч 1.254-д хүрлээ.

Гадаад худалдааны нөхцөл ийнхүү өөрчлөгдөхөд импортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.9%-иар, экспортын үнийн индекс 31.4%-иар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Экспортын үнийн бууралтанд зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефтийн хилийн дундаж үнэ буурсан нь голлон нөлөөлсөн бол импортын үнийн бууралтад нефтийн бүтээгдэхүүний үнэ буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	Эхний 11 сар			Өөрчлөлт			
	2015	2014	2013	2015/2014		2014/2013	
				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	7 737,5	10 022,6	9 716,4	(2 285,0)	-22,8%	306,1	3,2%
Экспорт	4 242,9	5 190,4	3 861,2	(947,5)	-18,3%	1 329,3	34,4%
Импорт	3 494,7	4 832,2	5 855,3	(1 337,5)	-27,7%	(1 023,1)	-17,5%
Тэнцэл	748,2	358,2	(1 994,1)	390,0		2 352,4	-118,0%

Дүрслэл 1. Экспорт, импортын өсөлтийн хурд /3 сарын гулсах дунджаар/



Дүрслэл 2. Валютын төлбөртэй худалдаа



Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индексийн өөрчлөлт /3 сарын гулсах дунджаар/



Бүтэц: 87% + 13%

Ашигт малтмалын бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 2%-иар буурч нийт экспортын 87%-ийг бүрдүүлэв.

Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр ба баяжмал, боловсруулаагүй нефть гэсэн голлох 4 түүхий эдийн экспорт ашигт малтмалын экспортын 85%, нийт экспортын 74%-ийг тус тус эзэлж байна.

Түүнчлэн энэ 4 бүтээгдэхүүний ашигт малтмалын экспортод эзлэх хувь 3 нэгж хувиар, нийт экспортод эзлэх хувь 4 нэгж хувиар тус тус буурсан байна.

Өсөлт: -18.3%

Экспорт өнгөрсөн оны мөн үеэс 18.3%-иар буурсан бөгөөд үүнд ашигт малтмалын экспортын бууралт голлон нөлөөлжээ. Гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн экспорт өнгөрсөн оны мөн үеэс харгалзан 33%, 9%, 49%, 40%-иар буурсан нь ашигт малтмалын экспортыг 20%-иар бууруулжээ.

Өөрчлөлт

Экспортын бүтээгдэхүүн тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалж 57.4 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,004.9 сая ам.доллараар буурснаар нийт дүнгээр 947.5 сая ам.доллараар буурсан байна.

Бүлэг тус бүрээр авч үзвэл ашигт малтмалын экспортын хувьд зэсийн баяжмал, боловсруулаагүй нефть, алтны тоо хэмжээ өссөнөөс шалтгаалж экспорт 293 сая ам.доллараар өссөн бол чулуун нүүрсний экспортын тоо хэмжээ буурсан, мөн зэсийн баяжмал, чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй нефтийн үнэ буурснаас шалтгаалж экспорт 1,070 сая ам.доллараар буурсан байна.

Ямааны угаасан ноолуурын тоо хэмжээ өссөн ч үнэ буурснаар уг бүлгийн экспорт 47.0 сая ам.доллараар буурсан. Харин бусад экспортын бүтээгдэхүүний хувьд үнэ болон тоо хэмжээ өссөнөөр өмнөх оны мөн үеэс 7.4 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхий зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Алтны дэлхийн зах зээл дээрх үнэ 2015 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар унц тутамд 1,064.8-д хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 8.8%-иар, өмнөх сараас 6.8%-иар тус тус буурсан байна.


А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 2015 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар харгалзан 4,599.3, 44.0 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэс 10.3%-иар, төмрийн хүдэр 12.0%-иар тус тус буурсан байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад зэс 28.3%-иар, төмрийн хүдэр 37.1%-иар тус тус буурчээ.

Хүснэгт 2. Экспортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)

	2015			2014			Өөрчлөлт		
	Тоо/хэм (мян.тн, мян.бар, кг)	Дүн	%	Тоо/хэм (мян.тн, мян.бар, кг)	Дүн	%	Дүн	Өсөлт	%
1. Ашигт малтмал	3 688	87%		4 596	89%		(908)	↓-20%	-17,5%
Чулуун нүүрс	12 831	508	12%	16 909	760	15%	(251)	↓-33%	-5%
Зэсийн баяжмал	1 335	2 072	49%	1 253	2 288	44%	(216)	↓-9%	-4%
Төмрийн хүдэр/баяж.	4 346	202	5%	5 554	401	8%	(198)	↓-49%	-4%
Боловсруулаагүй нефть	7 386	360	8%	6 330	602	12%	(242)	↓-40%	-5%
Цайрын хүдэр ба баяж.	84	102	2%	93	106	2%	(4)	↓-4%	0%
Мөнгөжөөгүй алт	9 474	357	8%	8 423	343	7%	14	↑4%	0%
Жонш, лейцит, нефелинт	257	60	1%	287	66	1%	(5)	↓-8%	0%
Молибдений хүдэр/баяж	4	27	1%	4	32	1%	(5)	↓-17%	0%
2. Ноос, ноолуур	229,3	5%		276,4	5%		(47)	↓-17%	-0,9%
Ямааны угаа ноолуур	4 818	191	5%	4 015	223	4%	(31,4)	↓-14%	-1%
Ямааны сам ноолуур	526	38	1%	554	54	1%	(15,6)	↓-29%	-6%
3. Бусад	325	8%		318	6%		7	↑2%	0,1%
Нийт дүн	4 243			5 190			(947,5)	↓-18,3%	

% - Бүлгийн өсөлтөө оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөө оруулсан хувь нэмэр (contribution to the growth)


Дүрслэл 4. Чулуун нүүрсний экспорт, зах зээлийн үнэ (ам.доллар)



Хүснэгт 3. Экспортын барааны өөрчлөлт (сая ам.доллар)

	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
		%		%		%
1. Ашигт малтмал	11		(919)		(908)	
Чулуун нүүрс	(183)	-73%	(68)	-27%	(251)	-33%
Зэсийн баяжмал	150	69%	(366)	-169%	(216)	-9%
Төмрийн хүдэр ба баяжмал	(87)	-44%	(111)	-56%	(198)	-49%
Боловсруулаагүй нефть	100	42%	(342)	-142%	(242)	-40%
Цайрын хүдэр ба баяжмал	(10)	-269%	7	169%	(4)	-4%
Мөнгөжөөгүй алт	43	307%	(29)	-207%	14	4%
Жонш, лейцит, нефелинт	(7)	-134%	2	34%	(5)	-8%
Молибдений хүдэр ба баяжмал	6	119%	(12)	-219%	(5)	-17%
2. Ноос, ноолуур	41,8		(88,8)		(47,0)	
Ямааны угаасан ноолуур	44,5	142%	(75,9)	-242%	(31,4)	-14%
Ямааны самнасан ноолуур	(2,7)	-18%	(12,9)	-82%	(15,6)	-29%
3. Бусад	4	56%	3	44%	7,4	2%
Нийт	57,4		(1 004,9)		(947,5)	

Дүрслэл 5. Дэлхийн зах зээл дээрх алт, цайр, зэсийн үнийн динамик



Бүтэц: 29% + 38% +13% +19%

Оны эхний 11 сарын байдлаар нийт импортын 29%-ийг хэрэглээний бүтээгдэхүүн, 38%-ийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 19%-ийг нефтийн бүтээгдэхүүн тус тус бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгж хувиар буурсан бол хэрэглээний бүтээгдэхүүн 3 нэгж хувиар өссөн байна.

Өсөлт: -27.7%

Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 13%-ийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 5%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 8%-ийг тус тус тайлбарлаж байна.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 32%-иар буюу 640 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 20%-иар буюу 250 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 38%-иар буюу 401 сая ам.доллараар буурсан нь нийт импортийг 27.7%-иар буюу 1,338 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

Задаргаа

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оны мөн үеэс 20%-иар буюу 250 сая ам.доллараар буурахад түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 15%-иар буюу 102 сая ам.доллараар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 26%-иар буюу 148 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа сахар, какао, шоколад болон согтууруулах, согтууруулах бус ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын бууралт голлон нөлөөлсөн. Хэрэглээний барааны импортын 3 сарын гулсах дунджаар тооцсон жилийн өсөлт тайлант хугацааны эцэст сөрөг тэмдэгтэй 19%-д хүрсэн /Дүрслэл 7/. 2014 оны эхний хагаст хэрэглээний барааны импортын өсөлт тогтмол байсан бол 6-р сараас эхлэн буурчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүний эд анги 34%-иар буюу 355 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 38%-иар буюу 280 сая ам.доллараар буурсан байна.

Аж үйлдвэрлэлийн орцын импорт 12%-иар буюу 63 сая ам.доллараар буурсан. Уг бууралтыг бусад аж үйлдвэрлэлийн зориулалттай орцын бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт 38%-иар буюу 401 сая ам.доллараар буурсан. Нефтийн импорт тоо хэмжээний хувьд өнгөрсөн оны түвшинд хадгалагдсан ч хилийн үнийн бууралтаас шалтгаалан нийт дүнгээр ийнхүү буурсан байна.


Нефтийн бүтээгдэхүүний хилийн үнэ 2013 оны төгсгөлөөс эхлэн тогтмол буурсан ба 2015 оны 2-р сард 2010 оноос хойшхи хамгийн доод түвшиндээ хүрсэн. Харин 2015 оны 3-р сараас эхлэн эргэн өссөн боловч 8-р сараас буурч 11 сарын байдлаар тонн тутамд 568.5 ам.долларт хүрсэн байна.

Хүснэгт 4. Импортын барааны гүйцэтгэл (сая ам.доллар)


Төрөл	2015		2014		Өөрчлөлт		
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт	%2
Хэрэглээний бүтээгдэхүүн	1 002	29%	1 252	26%	(250)	-20%	-5%
Түргэн эдэлгээтэй	583	17%	686	14%	(102)	-15%	-8%
Хүнс	403	12%	480	10%	(77)	-16%	-6%
Эм, тариа	67	2%	70	1%	(3)	-4%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	114	3%	136	3%	(22)	-17%	-2%
Удаан эдэлгээтэй	419	12%	567	12%	(148)	-26%	-12%
Гутал, хувцас, цүнх	46	1%	53	1%	(8)	-14%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	83	2%	122	3%	(39)	-32%	-3%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	232	7%	323	7%	(91)	-28%	-7%
Бусад удаан эдэлгээтэй бараа	58	2%	68	1%	(10)	-14%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	1 342	38%	1 982	41%	(640)	-32%	-13%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	687	20%	1 042	22%	(355)	-34%	-18%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	106	3%	260	5%	(154)	-59%	-8%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	581	17%	783	16%	(201)	-26%	-10%
Барилгын материал	451	13%	731	15%	(280)	-38%	-14%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	203	6%	208	4%	(5)	-2%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	471	13%	534	11%	(63)	-12%	-1%
Хүнсний орц	25	1%	31	1%	(6)	-19%	0%
Химийн бүтээгдэхүүн	81	2%	84	2%	(3)	-4%	-1%
Давау, утас, арьс, савхин эдлэл	14	0%	15	0%	(1)	-4%	0%
Цахилгаан эрчим хүч	117	3%	106	2%	11	10%	2%
Металлын хүдэр, баяжмал болон хаялдал	1	0%	0	0%	1	214%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат	232	7%	298	6%	(65)	-22%	-12%
Нефтийн бүтээгдэхүүн	650	19%	1 052	22%	(401)	-38%	-8%
Дизель тунш	348	10%	592	12%	(244)	-41%	-5%
АИ-92, АИ-95	209	6%	294	6%	(86)	-29%	-8%
А-80 болон бусад	94	3%	166	3%	(72)	-43%	-7%
Бусад	29	1%	13	0%	16		0%
Нийт дүн	3 495		4 832		(1 338)	-27.7%	

% - Булагийн өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)
% 2 - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to the growth)

Дүрслэл 6. Нийт импортын задаргаа /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 7. Хэрэглээний импортын хандлага /3 сарын гулсах дундаж/



Дүрслэл 8. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ

